



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 585

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Сумын төвийн шинэчлэл” төслийн хүрээнд Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын төвд барьж, ашиглалтад оруулсан нийт 5,000,000,000.0 (таван тэрбум) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан барилга, дэд бүтцийн байгууламж, холбогдох хөрөнгийг Хөвсгөл аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Болдод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. “Сумын төвийн шинэчлэл” төслийн хүрээнд Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын төвд бий болсон хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу эзэмшигч байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх ажлыг зохион байгуулах;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА



0002595

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 сарын 19-ний өдрийн
385 дугаар тогтоолын хавсралт

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр	Хөрөнгийн үнэ (төгрөг)
1	Цэвэрлэх байгууламжийн барилга, тоног төхөөрөмж	527,600,000.00
2	Ахуйн үйлчилгээний барилга	204,300,000.00
3	Халуун усны барилга	156,500,000.00
4	Автозам -1.2 км	592,000,000.00
5	Уурын зуухны барилга, тоног төхөөрөмж	516,100,000.00
6	Гадна дулааны шугам	1,534,300,000.00
7	Гадна бохир усны шугам	562,000,000.00
8	Усан сангийн барилга	323,000,000.00
9	Гадна цахилгаан хангамж	66,700,000.00
10	Сумын ерөнхий төлөвлөгөө	300,000,000.00
11	Гүний худаг	217,500,000.00
	Нийт дүн	5,000,000,000.00
		(таван тэрбум)